

хөрштэй, дэлхий бүс нутгийн улсуудтай найрамдалт өргөн харьцаатай байя гэвэл улсынхаа хил, түүний орчмын газар нутгийг найдвартай манаж, улс ард түмнийхээ язгуур эрх ашгийг тууштай хамгаалах нь хэнээс ч хамаарахгүй зүй тогтлын шинжтэй үйлдэл гэдгийг онцлон үзэж, хэзээ ч мартахгүй байх нь туйлын ач холбогдолтой гэж үзэж байна.

Энэ байр сууринаас хил хамгаалалтын зардлыг авч үзвэл ихсэж байгаа биш харин багасаж байгаа юм. Өгөөж нь монгол улсын эрчимтэй хөгжлийн тайван таатай нөхцөлийн баталгааг бүрдүүлж байгаад оршиж байна.

Ер нь Монгол Улсын хилийг өөрчлөх бололцоо олгохгүйгээр тухайлбал хилийн дагуу инженерийн төхөөрөмж хийх зэрэг бүх юм, тэр дотроос улсын хил хамгаалалтыг бэхжүүлэх чиглэлээр, жишээлбэл манаа харуулын байраас авахуулаад хилчдийн байлдсан, тулалдсаныг нотлох бүх юм үргүй зардалд тооцогдох ёсгүй билээ. Энэ бүхэн наагуур яривал Монгол Улсын батлан хамгаалалтыг баталгаажуулсан зайлшгүй гарах бодит зардалд хамаарагдана. Өргөн утгаар авч үзвэл улсын хил түүний орчимд хийгдэж бий болсон бүхэн Монгол Улсын тусгаар тогтнол мөнх оршиж байгаагийн баталгаа, түүний яндашгүй баялаг сан хөмрөгт оруулсан мөнхөрч үлдэх ёстой үнэт капитал юм.

*

*

*

*ХЦДС-ийн Сургалтын албаны дарга,
магистр, хурандаа М.Ахагвасүрэн*

МОНГОЛ УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦОО

Түүхийн эх сурвалжуудаас үзэхэд газар нутаг, хил хязгаарын маргаан нь дэлхийн улс үндэстнүүдийн зөрчил тэмцлийн шалтаг шалтгаан тэдгээрийн оршин тогтнох, эс оршихийг тодорхойлогч гол хүчин зүйл болсоор ирсэн.

Монгол Улсын тусгаар тогтнол хил хязгаарийн халдашгүй байдал олон зууны турш өөрчлөгдөн байсан хэдий ч устаж арилаагүйгээр барахгүй Монгол улсын төрийн хил хязгаараа баримтжуулан баталгаажуулах, хамгаалах, бэхжүүлэх талаарх бодлогын үр дүнд одоогийн хилийг тогтоож гэрээ хэлэлцээрээр

баталгаажуулсан нь бидний оршин тогтнохын гол нөхцөл билээ.

Гэвч орчин үеийн дэлхий ертөнцөд гарч буй хувьсал, хөрш их гүрний задрал болон хүчирхэг хоёр их гүрний хооронд оршин тогтнож буй бодит байдал, дотоодын нийгэм, эдийн засгийн хямрал зэрэг нь хил хязгаарын асуудалд хурцаар нөлөөлөхийг үгүйсгэх аргагүй. Ийм нөхцөл байдалд улсын хилийг хуулиар бататгах, хилийн асуудлыг улс төр-дипломатын аргаар зохицуулах, аливаа зөрчил будлианаас сэрэмжлэх, түүнийг хурцатгахгүйгээр шийдвэрлэх, хил залгаа улстай найрамдалт сайн хөршийн харилцааг бүх талаар хөгжүүлэх, хил хамгаалалт, хил хязгаарын дэд бүтцийг бэхжүүлэх, хил орчмын оршин суугчдын нийгмийн хангамжийг дээшлүүлэх талаарх төрийн бодлого зайлшгүй шаардлагатай.

Иймд төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг боловсруулахын тулд түүний зайлшгүйг нотлох шинжлэх ухааны онолын үндсийг боловсруулахад нь сургалт эрдэм шинжилгээний байгууллагууд гол үүрэгтэй.

Улсын хил хамгаалалт нь Монгол Улсын Үндсэн хууль бусад хуулиар баталгаажсан үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах арга хэмжээний салшгүй хэсгийн хувьд бусад салбаруудтайгаа диалектик холбоотой шинжлэх ухааны онолын тусгай салбар юм.

Улсын хил хамгаалалт нь нийгэм, улс төрийн нарийн үзэгдэл бөгөөд эх орны улс төр, эдийн засаг, цэргийн ашиг сонирхлыг хамгаалах талаарх цогцолбор арга хэмжээнүүдийн нийлбэр эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын болон олон улсын эрх зүйн харилцаа байнга өрнөж байдаг судалбал зохих объект болно.

Улсын хил хамгаалалт нь салбар шинжлэх ухааны онол болохын хувьд, түүний мөн чанараас урган гарсан хилийн дэглэм хил орчмын дэглэм, гэсэн ерөнхий болон хилийн алба, шалган нэвтрүүлэх алба, хилийн эрэл, хилийн төлөөлөгчийн ажиллагаа, өдөөн хатгалгатай тэмцэх зэрэг салбар ухагдахуунууд цэргийн шинжлэх ухааны байлдаан, тагнуул тактик, оператив урлаг, мөн түүнчлэн гэрээ хэлэлцээр, захиргааны хариуцлага, хэрэг бүртгэлт зэрэг эрх зүйн суурь ойлголтуудтай байдаг.

Улсын хил хамгаалалтын онолын нэг чухал шинж нь түүний суурь үзүүлэлт болсон эрх зүйн тогтолцоо юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т "Монгол Улсын хилийг хуулиар бататгана" гэж заасны дагуу батлагдсан Монгол

Улсын хилийн тухай хууль хилийн асуудлаарх Монгол Улсын олон улсын гэрээ, нэгдэн орсон бусад гэрээ, хэлэлцээрүүд, хилийн асуудлыг зохицуулахын тулд Монгол Улсын бусад хуулиудад орсон заалтуудад байдаг.

Аливаа нэг онолын шинжлэх ухааны гол үндэслэл, тулгуур үзэл санаа, үйл ажиллагааны үндсэн горим нь түүний илэрдэг.

Улсын хил хамгаалалтын зарчмууд нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан Монгол Улсын хил хамгаалалтын дүрэмд тусгагдсан байдаг ба түүнийг хэрхэн хэрэгжүүлж буйгаас улсын хил хамгаалалтын найдвартай байдал шууд шалтгаалдаг.

Улсын хил хамгаалах онол нь объект болон судлах зүйлийн өвөрмөц онцлог, үндсэн ойлголтуудын агуулга, судалгааны хууль эрх зүйн үндэс аргыг агуулсан нарийн бүтэцтэй болно.

Онолын бүтэц гэдэг ойлголт нь харьцангуй тогтвортойгоор юмс үзэгдэл, үйлдлийн харилцан үйлчлэлд орох холбоос өөрөөр хэлбэл объект болон субъектүүдийн харилцан шүтэлцээг илэрхийлнэ. Энэхүү бүтцээс Монгол улсын хил хамгаалалтын тогтолцоо буй болно.

Улсын хил хамгаалалтын нэгдсэн тогтолцоонд улс орны хэмжээнд хилийн асуудлаар төрийн бодлогын хүрээнд тавигдсан асуудлыг шийдвэрлэхэд хүч хэрэгслийг зохион байгуулалттайгаар татан оролцуулснаар гүйцэтгэх арга хэмжээнүүд багтана.Үүнд:

- цэргийн
- инженер-техникийн
- хил хяналтын
- хууль-эрх зүйн
- улс төр-дипломат
- гүйцэтгэх ажил, тагнуулын арга хэмжээ тус тус орно.

Цэргийн арга хэмжээ гэж Хилийн цэргийн штаб, хилийн тусгай анги, салбарууд, улсын хил манах, хилийн эрэл явуулах, өдөөн хатгалгатай тэмцэх ажиллагааг газар орон, цаг хугацааны хувьд байнга, тасралтгүй, идэвхтэйгээр харилцан ажиллан гүйцэтгэхийг хэлнэ. Энэ нь алба- байлдааны ажиллагаа, оператив –байлдааны ажиллагаа гэсэн хэсгүүдэд хуваагдана.

Инженер-техникийн арга хэмжээ гэж улсын хил, эдийн засгийн чөлөөт бүсийн хамгаалалтад цэргийн ажиллагааг инженер-техникийн арга хэмжээтэй хослуулах хилийг техник хэрэгслээр халхлах, хил

хамгаалалтад инженер-техникийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлнэ.

Хил хяналтын арга хэмжээ нь улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх үеийн Хилийн Цэрэг, гааль бусад хил хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг улс орны эдийн засгийн эрх ашигтэй уялдуулан зохицуулахтай холбогдсон нэгдмэл ажиллагаа юм.

Хууль эрх зүйн арга хэмжээ гэж улсын хилийн бүс, зурваст хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, хилийн боомтын журмыг мөрдүүлэх, хилийн зөрчил гаргагчид, хил зөрчигчдөд захиргааны хариуцлага хүлээлгэх, хэрэг бүртгэлт явуулах арга хэмжээнүүдийг хилийн төлөөлөгчийн газар /Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч /хил хамгаалах байгууллага, тагнуул, хууль хяналтын байгууллагатай хамтран явуулах иж бүрэн ажиллагааг хэлнэ.

Улс төр-дипломатын арга хэмжээ нь Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийг хүндэтгэн биелүүлэх, хилийн асуудлыг зохицуулах, хилийн дэглэмийг сахиулах, хилийн ус, хилийн шугам дээрх байгууламжийг ашиглах, хил орчмын байгаль орчин, ан амьтанг хамгаалах талаарх Хилийн төлөөлөгч, ХЦУГ болон төрийн захиргааны төв, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын арга ажиллагааг төрөөс зохицуулахыг хэлнэ.

Гүйцэтгэх ажил тагнуулын арга хэмжээ гэж улсын хилийн бүс, зурвас, хилийн боомт газар болон хил орчмын нутаг дэвсгэрт хил зөрчигчид, түүнд туслагч этгээдүүд болон хил давуулан зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгчид, Монгол Улсын эсрэг хандсан хорлон сүйтгэх ажиллагаа, хагалан бутаргах, өдөөн хатгах ажиллагааг илрүүлэх, улсын хилийг гүйцэтгэх ажлын шугамаар халхлахаар эрх бүхий байгууллагуудын явуулж буй тагнуул, сөрөг тагнуулын ажиллагааг хэлнэ.

Улсын хил хамгаалалтын цэргийн тогтолцоо

Монгол Улсын хилийн тухай хуулинд заасанчлан хилийн цэрэг тайван цагт газар, усны хилийг манах хилийн алба, улсын хилээр зорчигч тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх шалган нэвтрүүлэх алба болон улсын хилийн халдашгүй байдал алдагдан хилийн зөрчил гарсан хилийн эрэл явуулах, улсын хил дээр цэрэг улс төрийн байдал эрс хурцадсан үед хил дээр үүссэн зэвсэгт ба зэвсэггүй өдөөн хатгалгыг таслан зогсоох,

хорлон сүйтгэх тагнуулын ажиллагааг илрүүлэн устгах зэрэг улсын хилийг хориглон хамгаалах үүргийг гүйцэтгэнэ. Харин агаарын хилийн хяналтыг УАДХЦ гүйцэтгэдэг ба газрын хэвлийн хилийн хамгаалалт тодорхой харьяалалгүй байгаа.

Энэ бүгдээс дүгнэн үзэхэд улсын хил хамгаалалтад цэргийн тогтолцоо нь суурь арга хэмжээ болж байгаа бөгөөд хилийн алба, хилийн шалган нэвтрүүлэх алба, хилийн эрэл, өдөөн хатгалгатай тэмцэх (байлдааны) ажиллагаа зэрэг төрлүүд болон агаарын хилийн хяналт зэргээс бүрдэж байна.

Улсын хил хамгаалах үүргийг цэргийн байгууллага гүйцэтгэж байгаагийн нь хувьд Хилийн Цэргийн штабыг цэргийн мэргэжлийн удирдлагын байгууллага, хилийн тусгай ангийг тусгай хороо /бригад/, салбарыг рот-батальон гэсэн зэрэглэлээр цэргийн байгуулалтын ерөнхий зарчмын дагуу дүйцүүлэн ойлгож болно. Улсын хил хамгаалалтыг зохион байгуулан явуулдаг үндсэн байгууллага **хилийн хороо нь** Монгол Улсын хилийн тухай хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хариуцсан хилийн хэсэг дээрээ командлалын удирдамж, тушаал, захирамжийг үндэслэн хил хамгаалалтыг зохион байгуулан Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, улсын хил дээр эх орныхоо улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах, цэрэг-улс төрийн ач холбогдол бүхий хилийн цэргийн тусгай анги юм.

Хилийн хорооны бүтцэд хилийн шалган нэвтрүүлэх боомт, хилийн комендатур байж болно.

Хилийн хороо хоногийн турш улсын хилийг тасралтгүй манах, нэг зэрэг хоёр чиглэлд хилийн эрэл явуулах, эсвэл хорлон сүйтгэх тагнуулын 2-3 бүлгийг устгах болон хүч нэмэгдүүлсэн рот хүртэлх хүчний зэвсэглэсэн халдлагыг таслан зогсоох, батальон хүртэлх хүчний дайралтыг няцаах байлдааны боломжтой байх шаардлагатай. Хилийн хорооны алба-байлдааны боломж үүнээс доогуур байвал ашиггүй, үрэлгэн бүтцийг буй болгох талтай.

Хилийн салбар нь хилийн суман, хилийн комендатур, шалган нэвтрүүлэх боомтын хэлбэртэй байж болох ба хилийн суман нь хил хамгаалалтын үндсэн нэгж бөгөөд хилийн тодорхой хэсгийг хариуцан бүрэлдэхүүнээсээ хилийн харуул, манаа томилох журмаар хоногийн турш улсын хилийг манаж хилийн бүс зурваст байрладаг.

Хилийн сумангийн алба байлдааны боломж нь хариуцсан хилийн хэсгийг хилийн харуул манаагаар халхлах, хилийн эрлийг хариуцсан

хилийн хэсгийн нэг чиглэлд явуулах, хорлон сүйтгэх болон тагнуулын нэг бүлэг, тасаг хүртэлхи хүчийг устгах, салаа хүртэлхи хүчний дайралтыг няцаах хэмжээнд байна. Хилийн алслагдсан болон зөрчил ихтэй чиглэлийн хамгаалалтын удирдлагын шуурхай байдлыг хангах, хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх зорилгоор хэд хэдэн суманг хариуцсан хилийн салаа бүхий бэлтгэл хүчтэй хилийн комендатурыг хорооны харьяалалд байгуулж болно. Энэхүү комендатур нь хилийн суман дээр эсвэл хилийн бүсэд тодорхой чиглэлийг давхар халхлах маягаар байрлана. Хилийн комендатур нь хилийн тухай хууль, хил хамгаалалтын дүрэм, удирдамж тушаалын биелэлтийг хангуулах, дэглэм сахиулах ажиллагаанд голлон оролцоно.

Харуулын алба нь хилчдийн алба хаах нөхцөлийг сайжруулах, хил дээр байнга тодорхой хүчийг барьж байх, өөрөөсөө томилогдсон манаанд богино хугацаанд тусламж үзүүлэх зэрэгт ач холбогдолтой ба хилийн зөрчил ихтэй үед тодорхой хэсгийг халхлах, алслагдсан хэсгийг манахад ихээхэн тохиромжтой болно.

Хилийн шалган нэвтрүүлэх алба нь хилийн боомт газар явагддаг хил хамгаалалтын цэргийн тогтолцооны чухал төрөл юм. Хилийн шалган нэвтрүүлэх алба нь хилийн шалган нэвтрүүлэх хороо, хилийн шалган нэвтрүүлэх суман, шалган нэвтрүүлэх албаны манаа гэсэн гурван ангилалд хуваагдаж олон улсын зэрэглэлтэй байнгын болон түр хилийн боомтууд дээр зохион байгуулагддаг. Хилийн шалган нэвтрүүлэх албаны хувьд 1994 онд дүрэмтэй болсон ба 1999 оноос олон улсын хилийн боомт дээр байнгын хилийн шалган нэвтрүүлэх хороо 3 ажиллан түр боомт дээр нээгдэх үед хилийн хорооноос тусгайлан хилийн шалган нэвтрүүлэх суман байгуулах замаар үйл ажиллагаа явуулж байна.

Хил хамгаалалтын цэргийн тогтолцооны нэлээд төвөгтэй төрөл болох хилийн эрэл хил зөрчигчдийг саатуулахад чухал үүргийг гүйцэтгэнэ.

Улсын хил хамгаалалтын эрх зүйн тогтолцоо

Улсын хилийг тодорхойлох, тогтоох, хилийг тэмдэглэх хийгээд хилийн шугам, хилийн тэмдгийн байршлыг хамтран шалгах, хилийг арчлан хамгаалах улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах ажиллагаа нь олон улсын гэрээ эрх зүйн үндсэн дээр зохицуулагддаг.

Монгол Улсын өмнө зүгийн хил нь БНМАУ, БНХАУ-ын хооронд 1962 онд байгуулсан хилийн гэрээгээр тодорхойлогдож тогтоогдон

1975 онд НҮБ-д бүртгэгдэн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн болно.

1988 онд Монгол-Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай гэрээ, 1991 онд Монгол-Хятадын хилийн боомтын дэглэм, хил орчмын иргэд харилцан зөрчих тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрүүд байгуулагдсанаар гэрээ эрх зүйн боловсронгуй зохицуулалттай болсон.

Монгол Улсын хойд хил нь БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1958, 1976 онд байгуулагдсан хилийн гэрээнүүдээр тодорхойлогдон тогтоогдож, 1980 оны Монгол-Оросын хилийг дэглэм, хилийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай гэрээ, Монгол-Оросын хилийн боомтын дэглэм, улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай хоёр улсын Засгийн газар хоорондын 1988 оны хэлэлцээрүүдээр эрх зүйн зохицуулалттай болсон.

Мөн Монгол-ОХУ-ын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх болон улсын хилийн хамгаалалтын асуудлаар хамтран ажиллах хэлэлцээрүүд байгуулагдсан хил хамгаалалтын асуудлаар харилцан ажиллах, хилийн зөрчлийн асуудлыг шийдвэрлэхэд хууль хяналтын байгууллагууд хамтран ажиллах эхлэл тавигдсан гэж дүгнэж болно.

Монгол Улсын хил хамгаалалтын дүрмийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлан мөрдөж байгаа нь хилийн хороо, сумангийн өдөр тутмын алба, хилийн эрэл явуулах, өдөөн хатгалгатай тэмцэх ажиллагаа төлөвлөх, явуулах эрх зүйн зохицуулалт боллоо.

Мөн улсын хил хамгаалалтад иргэд байгууллагын оролцоог төрийн захиргааны төв болон тагнуул, хууль сахиулах байгууллага Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, иргэд гэсэн байдлаар Монгол Улсын хилийн тухай хуулиар зохицуулан иргэдийг хил хамгаалалтад татан оролцуулах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан заавраар нарийвчлан зохицуулж байна.

Улсын хил хамгаалалтын эрх зүйн тогтолцоо нь хилийн болон хил орчмын дэглэм сахиулахад тэргүүн зэргийн ач холбогдолтой төдийгүй хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл нь болно.

Улсын хил хамгаалалтын улс төр дипломатын тогтолцоо

Монгол Улсын хил хамгаалалтын улс төр-дипломатын тогтолцоо нь улсын хилийн асуудлаар Монгол улсын Олон улсын гэрээ, хэлэлцээр, протокол байгуулах, олон улсын гэрээ хэлэлцээр, конвенцэд нэгдэн орсноор үүснэ.

Монгол Улсын хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ нь улсын хилийг хамтран шалгах, хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулах гэсэн гурван үндсэн чиглэлээр байгуулагдсан гэрээ, хэлэлцээр, протоколоос бүрдэнэ.

Монгол Улсын хилийг тодорхойлох, тогтоох, өөрчлөх асуудлыг Монгол Улсын Их Хурал, улсын хилийг хамтран шалгах асуудлыг Монгол Улсын Засгийн Газар, хилийн дэглэм сахиулах ажиллагааг хилийн төлөөлөгч хариуцахаар Монгол Улсын хилийн тухай хуульд заасан.

Хилийн хамгаалалтын асуудал хурцаар тавигдан хилийн цэргийг дахин байгуулагдахад хилийн комиссар – төлөөлөгчийн үүргийг хилийн зарим отрядын дарга нар хавсран гүйцэтгэж иржээ. Монгол улс хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулах гэрээ эрхийн орчинг буй болгоход ихээхэн анхаарсны үр дүнд 1980 онд ОХУ-тай, 1988 онд БНХАУ-тай хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулах тухай Засгийн газар хоорондын гэрээ байгуулан энэхүү гэрээ ёсоор хилийн төлөөлөгч, орлогчийг Засгийн газар томилох /Монгол-Оросын гэрээний 23-р зүйл, 1 заалт/ ба уг гэрээнүүдэд хилийн төлөөлөгчийн үүрэг, ажиллах журмыг тусгай зүйл болгон тогтоосон юм.

1996 оноос эхлэн хилийн төлөөлөгчийн газруудыг байгуулах асуудал төрийн бодлогод тусгагдсан нь аливаа асуудлыг цэрэг зэвсгийн хүчээр бус энх тайвны замаар улс төр-дипломатын аргаар гэрээ хэлэлцээрийн журмаар зохицуулах дэлхий нийтийн хандлагатай уялдаж байна.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 23 дугаар заалтаар Монгол Улсын хилийн төлөөлөгч, орлогчийг Монгол Улсын Засгийн Газар томилох бөгөөд хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг улсын хилийн тодорхой хэсэгт хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шийдвэрлэх зорилготой бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийн тулд туслагч, нарийн бичгийн дарга, орчуулагч, мэрэгжилтэнг томилох, хилийн зөрчил, түүнтэй холбогдсон асуудлаар хэрэг бүртгэл явуулах, захиргааны хариуцлага хүлээлгэх, улсын хилийн дэглэм зөрчигчийн хувийн байдлыг тогтоохоор зөвшөөрөлтэйгээр 10 хоног хүртэл хугацаагаар саатуулах, хил залгаа улсын хилийн төлөөлөгчтэй хэлэлцээ хийх, албан тасалгаандаа төрийн далбаа байрлуулж, тээврийн хэрэгсэлдээ төрийн далбаа мандуулах эрх олгогдсон.

Улсын хилийн хяналтын тогтолцоо

Монгол Улсын хилийн хяналтын тогтолцоо нь Монгол Улсын олон улсын тавцан дээр эзлэх байр суурь, гадаад улс төр, эдийн засгийн бодлогоос ихээхэн шалтгаалан хөгжиж зорчигч, бараа эргэлт нэмэгдэхийн хэрээр Монгол Улсын хилийн боомт нь хоёр улсын хэмжээнд байснаа олон улсын чанартай хилийн боомтууд болон хөгжиж ирсэн түүхтэй.

БНМАУ-ын хил хамгаалах хууль, гаалийн хууль гарч, хилийн ариун цэврийн дүрэм, мал эмнэлгийн албаны дүрэм, мал эмнэлгийн албаны хилийн хяналтын дүрэм тус тус шинэчлэгдэн, 1978 оноос Консулын дүрэм үйлчлэх болсон нь хилийн хяналтын албадын хамтын ажиллагааг улам боловсронгуй болгосон. 1986 онд "Хил орчмын районд оршин суугаа БНМАУ, ЗСБНХУ-ын иргэд улсын хилийг нэвтрэх хялбарчилсан журмын тухай" Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулагджээ.

1988 онд Монгол-Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулах тухай, 1989 оны иргэд харилцан зөрчих тухай БНМАУ, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрийг үндэслэн "Монгол-Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай хэлэлцээрийг 1991 онд байгуулжээ.

Монгол Улсын хилийн боомт газраар зорчигч тээврийн хэрэгсэл, ачаа барааг улсын хилээр нэвтрүүлэх ажиллагааг Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Гаалийн тухай хууль, Монгол Улсын малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Монгол Улсын ургамал хамгаалаллын тухай хууль, Монгол Улсын эрүүгийн хууль зэрэг хууль эрх зүйн дагуу явуулна.

Монгол Улсын хилийн боомт дээр ажиллаж буй хил хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг тухайн хяналтын дээд байгууллагаас томилогдсон байцаагч нар гүйцэтгэдэг.

Монгол Улсын нээлттэй гадаад бодлогын үрээр манай улсын гадаад харилцаа өргөжихийн хэрээр хилийн хяналтын байгууллагын үүрэг роль улам нэмэгдэн хилийн хяналтад тэргүүний технологи, техник ашиглах шаардлага байнга шаардагдана.

Хилийн боомтод байгууллага болгон төлөөлөгчтэй байж, татвар, лиценз олгох нэрээр хилээр зорчигч, тээврийн хэрэгслээс хураамж авах сонирхол ихээхэн нэмэгдэж байгааг зогсоох, тээврийн хэрэгсэлд хил нэвтрэх зөвшөөрөл олгодог журмыг төвөг багатай

байдлаар шийдвэрлэх, хилийн боомтод хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулдаг комиссыг Засгийн газрын гишүүн удирддаг байх шаардлагатай байна.

Хилээр гаргаж буй бараар таваарт оногдуулж буй хураамж, татвар, аливаа хязгаарлалт хилийн асуудалд хэрхэн нөлөөлөхийг хууль тогтоогч болон гүйцэтгэгч засаглалын байгууллага онцгой анхаарч гадаадын суудлын машин хилийн боомтоор оруулах асуудлыг хориглосноор машины наймаа, ноолуурт янз бүрийн хязгаарлалт, татвар оногдуулснаар ноолуурын, спиртын татварыг нэмсэнээр спиртын гэх мэт дуулиант хэргүүд гарч түүнийг таслан зогсоход бага бус хөрөнгө шаардагдаж байгааг харгалзах хэрэгтэй байна.

Улсын хил хамгаалалтын тагнуулын тогтолцоо

Монгол Улсын хил хамгаалалтын тагнуулын тогтолцоо нь гүйцэтгэх тагнуулын болон цэргийн тагнуулын арга хэмжээнээс бүрдэнэ.

Хил хамгаалалтын тагнуулын тогтолцоо хэдий чинээ хүчирхэг, шуурхай байна, хилийн асуудлыг зохицуулах, хилийн дэглэмийг сахиулах, улсын хилийг манах, улсын хилээр зорчигч тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх болон улсын хилийг хориглон хамгаалах ажиллагаанд ихээхэн тустай, Монгол улсын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа болно.

Улсын хилийг гүйцэтгэх тагнуулын шугамаар хамгаалах үүрэг Монгол Улсын гүйцэтгэх ажлын тухай хуулиар Тагнуулын Төв Газар эрхэлдэг.

Хил хамгаалалтын түүхэн байдлаас судлан үзэхэд Ар монголын суман харуул нь өөрөөсөө туршуул явуулан хилийн цагийн байдлын шаардлагатай мэдээллийг цуглуулж байжээ. Мөн 1933 онд Хилийн Цэрэг дахин байгуулагдсан үеэс эхлэн хилийн отрядуудуудын дэргэд гүйцэтгэх ажил эрхэлсэн "Тав засаг" байгуулж ажиллуулсан нь улсын хилийн дархан байдалд халдагсдыг илрүүлэх, тэдгээрийг саатуулах, устгахад ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн төдийгүй чөлөөлөх дайнд Орос-Монголын цэрэг амжилттай байлдахад жинтэй хувь нэмэр оруулсан болно.

1994 оноос ХЦУГ-ын дэргэдэх тагнуулын нэгж татан буугдсанаас мэдээлэл хомсдон хилийн зөрчил өсөх, ахуйн чанартай зөрчил дээрмийн хэлбэртэй болох, улсын хилээр зохион байгуулалттайгаар олноор хүн, мал, машин, ноолуур, спирт гаргах

хууль бус ажиллагаа ихсэхэд нөлөөлсөн.

Хилийн зөрчлийг гарахаас нь өмнө мэдэж чадахгүйн улмаас хил хамгаалах байгууллага, хилийн манаа, хилийн зурвас, хилийн шугам дээр илрүүлэн түүнийг таслан зогсоож чадахгүй алдах, эсвэл зэвсэг хэрэглэн зогсоох аргагүй байдалд хүрдэгээс хил орчмын нутаг дэвсгэрийн ард иргэдийн дунд дургүйцэл төрөх, нутгаасаа дайжин нүүх, хилийн асуудлыг зохицуулах, хилийн дэглэм сахиулахад төвөг учруулахуйц сөрөг үр дагаврыг үүсгэж байна.

Монгол-Оросын хооронд тагнуулын байгууллагууд хамтран ажиллах талаар хоёр улсын хил хамгаалах байгууллагуудын түвшинд тохиролцсон ажиллаж байна.

Ийм хэлбэрийн хамтын ажиллагаа Монгод-Хятадын хооронд байхгүй. Монгол-Хятадын хооронд хилийн холбогдолтой мэдээллийг хилийн төлөөлөгчийн уулзалт, хэлэлцээний үед солилцдог болно.

Монгол Улсын хил хамгаалалтын тагнуулын тогтолцоонд цэргийн тагнуулын үйл ажиллагаа чухал байр суурийг эзэлнэ.

Монгол Улсын хил хамгаалах байгууллага тайван цагт Монгол Улсын хилийг манах, хил зөрчигчийг эрж саатуулах ажиллагаанд цэргийн тагнуулын арга ажиллагааг өргөн ашигладаг.

Хилийн тусгай анги, салбаруудын хилийн дагуух одоогийн байрлал нь тайван цагт ч, улсын хил дээр цэрэг-улс төрийн цагийн байдал эрс хурцадсан үед цэргийн тагнуул явуулахаар дэлгэн байрлуулсан бэлэн хүч хэрэгсэл болно.

Хилийн тусгай анги, салбаруудын тактиик ажиллагаа, хүч хэрэгслийн боломж, холбооны сүлжээ, уналга, хэрэгсэл нь өөрөөсөө жижиг бүлгүүдийг томилон ажиллуулж их талбайг хамарсан тагнуулын ажиллагаа явуулах өргөн боломжийг олгож байна.

Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын хилийн шугамын дагуух хилийн зурвас, бүс, өөрөөр хэлбэл хилийн шугамнаас дотогш 30 км, зарим газар 100 км гүнтэй газар орны хэсгийг өөрийн хяналтандаа байлгадаг.

Хилийн тусгай анги, салбарууд, өөрийн хяналтад байдаг газар орныг сайн мэддэг, нутгийн иргэдийг таньдаг зэрэг давуу талууд байдаг.

Хилийн тусгай анги салбаруудыг улсын хил дээр цэрэг-улс төрийн цагийн байдал хурцадсан болон хил халхлалтын үед цэргийн тагнуулын үүрэг гүйцэтгүүлэх нь ихээхэн ашигтай бөгөөд тайван цагт энэ чиглэлээр хилчдийг сургаж бэлтгэх шаардлагатай.

Тагнуулын хүч хэрэгслийг хил хамгаалалтын эрх ашигт

төвлөрүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн Газар Тагнуулын байгууллагын тухай хуулиар зохицуулж болно.

Хил хамгаалах байгууллагын тагнуулын байгууллага байгуулснаар хилийн шугамнаас доторх ирүүлэлтийн гүнийг нэмэгдүүлэх, цэргийн оператив тагнуулын сүлжээнд хил хамгаалах байгууллагыг оруулснаар хилээс гадагш хяналтад байхыг зурвасын гүнийг нэмэгдүүлж, ингэснээр хилийн зөрчлийг хилийн бүс зурваст таслан зогсоох магадлал ихээхэн нэмэгдэнэ.

Улсын хил хамгаалалтын инженерийн тогтолцоо

Улсын хил хамгаалалтын инженерийн тогтолцоо нь хилийн шугамын явалтыг баримтжуулах, хилийн тусгай анги салбаруудын алба-байлдааны боломжийг нэмэгдүүлэх, хилийн тодорхой хэсгийг халхлах зэрэгт чиглэгдсэн инженер-техникийн хэрэгслийн болон инженерийн байгууламжуудын цогцолбор арга хэмжээнүүд болно.

Монгол Улсын хилийн шугамын явалтыг баримтжуулах ажиллагаа нь улсын хилийн шугам, хилийн тэмдгийн байршлыг газар дээр нь тогтоон, хилийн тэмдгээр хил залгаа улстай хамтран тэмдэглэх, хилийн шугам, тэмдгийн байршлыг хамтран шалгах зэрэг ажиллагаануудаас бүрдэнэ.

Монгол Улсын хилийг тогтоох Монголын талын бүрэлдэхүүний Монгол Улсын Их Хурал томилох ба энэ бүрэлдэхүүн улсын хилийг хил залгаа улстай байгуулсан гэрээний дагуу газар дээр нь геодезийн аргаар тодорхойлж, тод харагдах бат бэх хилийн тэмдгээр тэмдэглэнэ.

Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, протоколд заасны дагуу хилийн шугам, хилийн тэмдгийг байршлын хил залгаа улстай хамтран шалгана.

Монгол Улсын хилийг хилийн дэглэмийн гэрээний дагуу арчлан хамгаалах асуудлыг Монгол Улсын хилийн төлөөлөгч хариуцдаг ба Монгол, Орос, Хятадын Засгийн газар хоорондын протокол, гэрээний заалтыг үндэслэн эвдэрсэн хилийн тэмдгийг засварлах, хилийн тэмдгийг анх босгосон цэг дээр нь сэргээн босгох, хилийн тэмдгийн байршлыг хилийн шугамын явалтыг өөрчлөхгүйгээр өөр цэг дээр шилжүүлэн босгох эрх эдэлдэг.

Монгол Улсын хилийн шугамыг баримтжуулах хүрээнд анхаарал татсан асуудал усан хилийг тэмдэглэх ажиллагаа болно. Усан хилийн нуурын хэсэг дээр хилийн шугамыг явалтыг тэмдэглэх ажиллагаа Монгол-Оросын хилийг хамтран шалгах явцад Увс нуурт

хийгдсэн ба Буйр нуур дээр хилийн шугамын явалтыг тэмдэглэх ажиллагаа огт хийгдээгүйгээс Хятадын талаас хил зөрчих асуудал ихээхэн гарч түүнийг нотлох, таслан зогсоох талаар маанай талаас ямар ч арга хэмжээ авах бололцоогүй байдгаас энэ хэсгийн хилийн халдашгүй дархан байдал байнга зөрчигддөг.

Өвлийн цагт нуурын мөс хөлдмөгц хоёр талын хилийн төлөөлөгч нар харилцан тохиролцсон мөсөн дээр цасан овоо босгож хилийн шугамын явалтыг баримжаалан тэмдэглэж буй ажиллагаа юм.

Монгол Улсын хилийн шугам голын хэсэгт төв гольдролоор явдаг ба энэ хэсэгт хилийн шугамын явалт байгалийн нөлөөллөөс үүдэн өөрчлөгдөх явдал хилийн хамтарсан шалгалтын явцад илэрдэг.

Хилийн тодорхой хэсгийг инженерийн төхөөрөмжөөр халхлах арга хэмжээ хилийн цэргийн хувьд эхлэл төдий байгаа. Хилийн зөрчил ихтэй зарим хэсгийн халхлалтад дохиоллын төхөөрөмж бүхий торон хашааг ашиглах асуудал Оросын хилийн цэргийн хил хамгаалалтын туршлагаар нэвтэрч эхэлсэн.

Өмнөд хилийн Замын-Үүдийн хилийн хэсгийн халхлалтад дохиоллын төхөөрөмж бүхий торон хашааг ашиглаж байна. Ийм төхөөрөмж нь хаана хилийн зөрчил гарсныг автомат дохиоллоор хилийн салбар руу мэдээлдэг ба үүний дагуу хилийн эрэл зохион байгуулан хил зөрчигчийг саатуулах боломж олгодог.

Мөн хоногийн турш хилийн үлэмж хэсгийг бага хүчээр халхлан хянах боломжийг олгодог давуу талтай. Энэ төхөөрөмжийг техникийн хянах харуултай хослуулан ашиглах нь ихээхэн ач холбогдолтой ба суурин газар болон эдийн засгийн чөлөөт бүсүүдийн хамгаалалтад ашиглах боломжтой. Энэ төхөөрөмж нь байнгын цахилгааны эх үүсгэвэр шаарддаг, мал амьтан нэвтрэх, цахилгаан дамжуулдаг эд юмс торон хашаанд наалдсан үед дохиоллын систем нь ажиллан хуурамч дохио өгдөг зэрэг сөрөг талуудтай болно.

Хилийн инженерийн төхөөрөмжийг сайжруулах арга хэмжээг тодорхой бодлогоор явуулахгүй бол хил дээр хилийн баганаас өөр инженерийн төхөөрөмжгүй үлдэж болзошгүй. Хилийн мөр хянах зурвас, өргөст торон хашаа нь түймэр эсэргүүцэх, мал бэлчээрээр хил давахыг сэргийлдэг эдийн засгийн ач холбогдолтойн хувьд Монгол Улсын хилийн тухай хуулийн дагуу орон нутгаас төсөв гаргуулах журмаар сайжруулж болох талтай. Хойд хилд хүрэхэд хүндрэлтэй хилийн хэсэгт зам гүүр барих ажлыг орон нутагтай хамтран хил орчмын нутаг дэвсгэрийн дэд бүтцийг хөгжүүлэх асуудалтай уялдуулан явуулж болно. Үүний тулд байгалийн баялгийг ашиглах асуудлыг эхлээд хил орчмын нутаг дэвсгэрээс эхлэн нутгийн гүн рүү чиглэсэн байдлаар

зохион байгуулах нь хил хамгаалалтын хувьд ихээхэн ач холбогдолтой болно. Хилийн Цэргийн одоогийн хүч хэрэгсэл, төсвийн байдал, инженерийн арга хэмжээг шаардлагатай түвшинд байлгах боломж хомс тул хилчдийг морь, тэмээ, туулц сайтай автомашин мотоциклоор хангах, нисдэг тэрэг хил хамгаалалтад ашиглаж байсан уламжлалыг сэргээх нь инженерийн халхлалтын орон зайг нөхөхөд чухал ач холбогдолтой болно. Энэ бүгдээс дүгнэн үзэхэд Монгол Улсын хил хамгаалалт нь улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хилийн тухай тогтоомжийг хэрэгжүүлэхээр эрх бүхий байгууллагаас явуулж буй улс төр дипломат, эрх зүй, хилийн хяналт, тагнуул, цэргийн болон инженер-техникийн арга хэмжээнүүдийн цогцолбор ажиллагаа гэж тодорхойлж болох юм.

*

*

*

*ХИЦС-ийн ШНА-ны тэнхимийн
ахлах багш дэд хурандаа Г.Төртөгтох*

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦООНД ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБАНЫ ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ, ХЭТИЙН ТӨЛӨВ

Монгол Улсын төрөөс баримтлах хилийн бодлогын үндсэн нэн чухал зорилго бол улсын хил болон хязгаар нутагт улс, үндэсний аюулгүй байдлыг хангах явдал мөн. Харамсалтай нь энэ бодлого өнөөг хүртэл байхгүй байна. Монгол Улсын тусгаар тогтнол, бие даасан байдал болон бүрэн бүтэн байдал нь түүний хилийн тогтонги чанар, найдвартай хамгаалалттай шууд холбоотой байдаг.

Өнөөг хүртэл бидний ярьж хэвшсэн улсын хил хамгаалалт гэдгийг өргөн утгаар нь *улсын хилийн аюулгүй байдлыг хангах* гэж томъёолж болно гэж үзэж байна. Тэгвэл хилийн аюулгүй байдал нь улс үндэсний аюулгүй байдлын нэг үндсэн бүрэлдэхүүн хэсэг байх ёстой. Аливаа улс орны тогтвортой байдал нь түүний хилийн аюулгүй байдалтай нягт холбоотой байдаг. Үндэсний аюулгүй байдалд хилийн аюулгүй байдлын эзлэх байр суурийг доорхи байдлаар бүдүүвчид тусгаж болох юм.